



# Хичээлийн сэдэв



# Хичээлийн зорилго



Эхэд дүрслэх ба дуурайх,  
дүрслэх үгийг хэрэглэсэн  
учрыг тайлбарлаж,  
найруулгын утга, үүргийг  
тодорхойлох



Эхэд давтан хэрэглэсэн  
дуурайх, дүрслэх үгийг  
өгүүлэгчийн хандлага  
үнэлэмжийг тайлбарлах




Дуурайх, дүрслэх үгийг  
ойролцоо утгат үгээр  
солин найруулах, утгын  
ялгааг ярилцах




Авианы найруулгын  
онцлогийг дүрс дуурайх үг,  
авиа дуурайх үгийн утгын  
ялгааг гаргасан өгүүлбэр  
зохиох


# Дуурайх , дүрслэх үгийн найруулгын үүрэг




Дуурайх, дүрслэх үгс нь юмс үзэгдэл, үйл хөдлөлийн хэлбэр дүрс , дуу авиаг нүдэнд харагдаж, сэтгэлд буутал дүрслэхээс гадна дүрсэлж буй зүйлдээ хандах зохиогчийн үнэлэмж хандлагыг илэрхийлдэг.



Үйлийн байдлыг эрчимжүүлж, тодотгодог.



Үг болон үеийн хэмжээ, аялгыг тэгшитгэх, яруу сонсголонтой болгодог.



Үйлийн дүр байдал, дуу чимээг тоочин дүрслэхэд чухал хэрэглүүр болно.

# Үйл ажиллагаа 1

## Эхийг уншиж ойлгоод, дуурайх үгсийг түүж бичье

### АЯН ЗАМЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС

Өглөөний зэсэн улаан наран Жинст хайрхны оройд мэлтийн тусах үес Цагаан хаалга гэдэг их хавцлын аманд хүрэв. Хоёр талын барсгар чулуун байцад говийн агь өвсний хөх бут ов тов харагдаж, хавцлыг уруудан хүүгэх салхинд тогтож ядан өрвөлзөнө. Ханан байцын сэрвэгэр оройд хээрийн хүүрзгэнэ шувуу нугдайн сууцгаана.

Алтайн цагаан хаалгаар чүү чаа уруудахад чулуун хана улам эрс болон сүндэрлэж, сэтгэл цухалдам давчуу байдлыг төрүүлнэ. ...ачааны машин арай чарай багтах явцуу тохойн өндөр эргэн дээр лавтай ойчих болов уу гэмээр бул хар чулууд

өчүүхэн суурин дээр дэнхийн данхайж, тэнцвэрээ олж ядан дэнжгэнэн байгаа мэт харагдана. ...Нэгэн байц хадны толин элгэн дээрээс шууман харцага сүр сар нисэн босож, агаарт дэрвэлзэхүйеэ буун дуу тас няс хийж, чимээ нь тэнгэрийн дуу мэт нижигнэн цуурайтахын сацуу уулын сүрэг бялзуухай цочин, дэрхийн нисэн одно.

Алтайн цагаан хаалга бидний ард орхигдохын сацуу нүдэнд хязгааргүй их говь цөл мэлцийн цэлийлээ. Задгайн тал нь мэлгэр тэгш газар харагдавч туулах үес энхэл донхол тул зогсох саатах нь олон байв. Ногтруу шувууд цочин тураг тураг дуугаран, жорго жорго хийн, замаас зайлна... Баруун зүгт ойрхон мэлцийм сул элсэн уул, зүүн зүгт холхон Атас Богд арзайн сүндэрлэж, түүнээс нэлээд нааш Дэл уул дэглийж. Сүүл уул сүүмэлзэнэ. Өмнө зүгт өргөн говь цэлийж, энд тэнд өнчин ганц заг мод өрвийн сөрвийнө.  
(Д.Цэвэгмид)

# Үргэлжлэл

1. Эхээс түүж бичсэн дүрслэх, дуурайх үгсийг утга, үүргийн ялгаатай болон төстэй шинжээр нь ялган бичээрэй.

Дуурайх үг

Хүн амьтны дуу авиаг дуурайх:

**сүр сар**

.....  
.....  
.....  
.....

Ю м үзэгдлийн дуу авиаг дуурайх:

**хүүгэх,**.....

.....  
.....  
.....  
.....

Дүрслэх үг

Хүн амьтны дүрс дуурайх:

**нугдайн,**

.....  
.....  
.....  
.....

Юмс үзэгдлийн дүрс дуурайх:

**өрвөлзөнө,**.....

.....  
.....  
.....  
.....

# Үйл ажиллагаа 2

- Өгүүлбэрт тэмдэглэсэн үгсийг ойролцоо утгат үгээр солин найруулахад утгын ямар ялгаа гарч байгааг үг тус бүрээр тайлбарлаарай.

- ❖ Хоёр талын **барсгар** чулуун байцад
- ❖ Говийн агь өвсний хөх бут **ОВ ТОВ** харагдаж
- ❖ Хавцлыг уруудан **хүүгэх** салхинд
- ❖ Тогтож ядан **өрвөлзөнө**.
- ❖ Ханан байцын **сэрвэгэр** оройд
- ❖ Дэнжигнэн байгаа мэт харагдана.
- ❖ Тэнгэрийн дуу мэт **нижигнэн** цуурайтах

Жишээ нь: “**барсгар**” гэдэг үг нь байц хадны дүр байдлыг илүү зохистойгоор тодотгож өгсөн ба **бүрзгэр, бурзгар, арзгар** гэдэг үгсийн аль нэгээр солин найруулахад найруулгын уран яруу, сонсголонтой байдал нь алдагдахад хүрч байна гэх мэтээр тайлбарлан бичнэ.

## Ойролцоо утгатай үгс

- \ **бүрзгэр, бурзгар, арзгар**
- \ **алаг цоог, өөг сөөг, өм цөм**\
- \ **шуугих, сийгэх**\
- \ **өрвийнө, сэрвийнэ**\
- \ **сарвагар, сөрвөгөр, сэрийсэн**\
- \ **Донжгонон, санжганан**\
- \ **Нужигнан, пижигнэн, тачигнан**\

## Санамж:

Дуурайх ба дүрслэх үг нь үйлийн дүр байдал, дуу чимээг нүдэнд үзэгдэж, чихэнд сонсогдтол дүрслэдэг. Мөн тухайн үгс нь үйлийн шинжийг тодотгож, өгүүлэгчийн сэтгэлийн өнгө аясыг илтгэж, үйлийг тоочин дүрслэх нэг хэрэглүүр болдог гэдгийг анхаараарай.

## Үйл ажиллагаа 3

**Өгүүлбэрт байгаа давталтууд ямар үүрэгтэй байгааг тайлбарлан бичье.**

- Хойд зүгт **гангар гунгар** хийлцэн урамтай л давхилдав.
- Намрын салхи **сэр сэр** салхилна.
- Оросын паар тэрэг **хөв хөв, тар тар** гэж таржигнуулсаар...
- Загас жараахай энд тэнд **пол пол** хийж байна.
- Энэ тэр этгээдээс гуншилдан **гүн ган** бархиралцаад...
- Олон одон **жирэв жарав** гийлцэнэ.

**Тайлбар:**

**Өгүүлбэрт дуурайх ба дүрслэх үгийн давтан хэрэглэхэд :**

1. Үйлийн байдлын дүр дүрслэл, шинжийг илүү тодотгож өгч байна.
2. Өгүүлэгчийн хандлага үнэлэмж буюу сэтгэлийн өнгө аясыг илэрхийлж байна. Жишээ нь: **Зохиогч эрдэм номын их аянд явах гэж буй учраас маш урам зоригтойгоор явж байгаа өнгө аяс илэрч байна. Мөн Берлин явах зам зуурын газар орны юмс үзэгдэл, байгалийн өнгө төрх, гадаад ертөнцийн хөгжил дэвшил зохиогчид гайхмаар сонин содон сонирхолтой сэтгэгдэл төрүүлж байгаа байдал илэрч байна.**
3. Үг болон үеийн хэмжээ, аялгыг тэгшитгэх зэрэг үүрэгтэй байна.

# Үргэлжлэл

Дүрслэх дуурайх үгсийг орхиод бичвэл өгүүлбэрийн утгад өөрчлөлт гарч байна уу?

- Хойд зүгт **гангар гунгар** хийлцэн урамтай л давхилдав.
- Намрын салхи **сэр сэр** салхилна.
- Оросын паар тэрэг **хөв хөв, тар тар** гэж таржигнуулсаар...
- Загас жараахай энд тэнд **пол пол** хийж байна.
- Энэ тэр этгээдээс гуншилдан **гүн ган** бархиралцаад...
- Олон одон **жирэв жарав** гийлцэнэ.

- Хойд зүгт урамтай л давхилдав.
- Намрын салхи салхилна.
- Оросын паар тэрэг таржигнуулсаар...
- Загас жараахай энд тэнд байна.
- Энэ тэр этгээдээс гуншилдан бархиралцаад...
- Олон одон гийлцэнэ.

- Өгүүлэгчийн хандлага үнэлэмж, сэтгэлийн өнгө аяс болон үйлийн байдлын дүр дүрслэл, шинжийг илэрхийлж буй байдал нь алдагдаж байна.



# Үйл ажиллагаа 4

- Зохиогч яагаад энэ шүлэгт дүрслэх дуурайх үгийг сонгосны учир юу вэ? Эдгээр үгс нь эхэд ямар утга үүрэгтэй байна вэ?
- Эхэд байгаа дүрслэх, дуурайх үгийг хасаад уншихад, утга нь хэрхэн өөрчлөгдөж байна вэ? Өөрийн үгээр тайлбарлаарай.

## Пионерийн зуслан

Борооны дусал шивэр шивэр ороод  
Булгийн ус пор пор үндраад  
Хойтруу хор хор хоржигноод  
Хос салаа усан мөчир болоод  
Бүлт хүүхэд гол шод гүйдээд  
Бүлчин мах эрчлэн мүшгиран чангараад  
Олон хүүхэд ярс ярс жагсаад  
Улаан бүч эрвэс дэрвэс хийсээд  
Ийм л сайхан  
Тийм л соньхон

Сэрүүн салхи сэр сэр үлээгээд  
Сэтгэл зүрх лүг лүг хөдлөөд  
Улбар түг намирс намирс мандаад  
Улаан судал нэвт шүвт лүгшаад  
Би, чи нэг адил нөхөрлөөд  
Бид нар, та нар нэг хамт жагсаад  
Цог жавхлангаа үүсгэн бадруулаад  
Цовоо зангаа гарган хүмүүжээд  
Ийм л сайхан  
Тийм л соньхон

Ц. Дамдинсүрэн

# Хичээлээ дүгнэе

## Дүрслэх , дуурайх үгийн найруулгын онцлог

1

Үйлийн  
шинжийг  
заана

2

Үйлийн  
байдлыг  
эрчимжүүлж  
тодчилно.

3

Өгүүлэгчийн  
хандлага,  
үнэлэмжийг  
илэрхийлнэ.

Анхаарал тавьсанд баярлалаа.